

Венчур Капиталын Хөрөнгө Оруулалтын Хөтөлбөр II Хоёр дахь дугтуй

Байршил:

Бүс нутгийн

Төслийн дугаар:

51558

Бизнесийн салбар:

Мэдээлэл, харилцаа холбооны технологи

Мэдэгдлийн төрөл:

Хувийн

Байгаль орчны ангилал:

FW

Захирлуудын зөвлөлд танилцуулах тов:

2019 оны 11-р сарын 27

Төлөв байдал:

Эцсийн хяналтанд тэнцсэн, Захирлуудын зөвлөлөөр батлагдахаар хүлээж буй

ТХББ-ийн Англи хэл дээрх хувилбарыг нийтэд танилцуулсан огноо:

2019 оны 10-р сарын 25

Төслийн танилцуулга

ЕСБХБ нь өөрийн Венчур Капиталын Хөрөнгө Оруулалтын Хөтөлбөр II (“ВКХОХ II” нь ЕСБХБ-ны хэрэгжүүлж буй ВКХОХ-ийн үргэлжлэл бөгөөд 100 сая еврогийн тусгай зориулалттай хөрөнгө оруулалтын сан юм)-оор дамжуулан компанийн хувьцаа буюу дүрмийн санд шууд хөрөнгө оруулах, эсвэл шууд хөрөнгө оруулалттай холбоотой санхүүгийн арга хэрэгслүүд (хөрөнгө оруулалт тус бүр нь 15 сая евро хүртэлх хэмжээтэй)-ийг ашиглах хэлбэрээр венчур капиталын түршлагатай хөрөнгө оруулагчидтай хамтран тус Банкны үйл ажиллагаа явуулдаг улс орнууд дахь эхлэлтийн болон өсөлтийн шатандаа яваа технологийн компаниудад хөрөнгө оруулдаг. Хөрөнгө оруулалт нь зах зээл дээрх венчур капиталын хөрөнгө оруулалтын дутуу орон зайг нөхөхөд тус дөхөм болох үүднээс хязгаарлагдмал эх үүсвэр бүхий венчур капиталын

хөрөнгө оруулалтын сангуудаас үйлчилгээ авч чадахгүй байгаа шинэлэг болон өсөлт өндөртэй жижиг ба дунд хэмжээний компаниудад хүрэх зорилготой. Хөрөнгө оруулалтын түвшинг тогтвортой байлгах, одоо байгаа эх үүсвэрийн үр өгөөжийн эрэлт хэрэгцээг хангахын тулд ВКХОХ II-ын хэрэгжилтийн үлдсэн хугацаанд хуваарилах нэмэлт санхүүжилт бүрдүүлэхийг зорьж байна.

Төслийн зорилт

i) ВКХОХ нь Банкыг тухайн Бүс нутагт мэдлэгийн эдийн засгийг дэмжих, технологийн экосистемийг хөгжүүлэх болон инновацийг дэмжих нөхцлөөр хангадаг; ii) Банк нь ВКХОХ-өөр дамжуулан Бүс нутагт буй болсон венчур капиталын санхүүжилтийн дутмаг байдлыг арилгахад чухал үүрэг гүйцэтгэдэг; iii) ВКХОХ нь Банкинд өндөр эрсдэлтэй / өндөр үр өгөөжтэй хөрөнгө оруулалтын боломжуудын багцын хандлагыг төлөвшүүлэх бололцоо олгодог.

Шилжилтийн нөлөөлөл

ВКХОХ II Сан нь саяхан байгуулагдсан, маш шинэлэг санаа бүхий технологийн дэвшилтэд суурилсан компаниудын хөгжлийг дэмжих тул Өрсөлдөх чадвартай, Уян хатан шилжилтийн хэв шинжийг хангахад хувь нэмэр оруулах бөгөөд ЕСБХБ-ны үйл ажиллагаа явуулж буй Бүс нутагт эхлэлтийн шатандаа байгаа хэдий ч хөгжих боломжтой венчур капиталын хүртээмжийг нэмэгдүүлэхэд түлхэц болно гэж тооцоолж байна. ВКХОХ II Сан нь анхны ВКХОХ I Сангийн гаргасан амжилтад тулгуурлах ба ЕСБХБ-ны Мэдлэгийн Эдийн Засгийн Санаачилга, ялангуяа түүний 3 дугаар үрсгалын Технологид суурилсан жижиг компаниудын талаар баримтлах зарчимд нийцүүлэн тус Банкны үйл ажиллагаа явуулж буй Бүс нутагт мэдлэгийн эдийн засгийг хөгжүүлэх чиглэлд голлох дэмжлэг түслалцаа үзүүлнэ.

Харилцагчийн мэдээлэл

Тухайн нөхцөл байдалд тохируулан авч үзнэ.

ЕСБХБ-ны санхүүжилтийн дүн

50,000,000.00 евро

Төслийн нийт өртөг

50,000,000.00 евро

Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн хураангуй

Энэхүү Сан нь Банкны 2014 оноос баримталж ирсэн Байгаль орчин болон Нийгмийн Бодлогын хүрээнд ангилагдаагүй болно. Гэхдээ дэд төслүүд тухайн нөхцөл байдлаас хамааран нэг бүрчлэн ангилагдах бөгөөд дэд төсөл ба харилцагч тус бүрийн онцлогт нийцсэн Ногоон Эдийн Засгийн Шилжилт (“НЭЗШ”)-ийн хяналт шалгалт болон байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (“БОННБНУ”)-нд хамрагдана.

Дэд төслийн ангилалд үндэслэн тохирох БОННБНУ нь дэд төсөл тус бүр Банкны Гүйцэтгэлийн Шаардлага (“ГШ”)-д нийцэхүйц бүтэцтэй болохыг батална.

Техникийн хамтын ажиллагаа

Байхгүй.

Компанийн холбоо барих мэдээлэл

Бахром Ибрагимов
02073386000

Бизнесийн боломжууд

Бизнесийн боломжууд болон худалдан авах ажиллагааны талаар харилцагч компанитай холбогдоно уу.

Төрийн хэвшлийн төслүүдтэй холбоотой мэдээллийг [EBRD Procurement](#) вэбсайтнаас авна уу: Утас: +44 20 7338 6794
Цахим шуудан: procurement@ebrd.com

Ерөнхий лавлагаа, үйл ажиллагаатай холбоотой асуулт

ЕСБХБ-ны төслүүдийн худалдан авах ажиллагаанаас бусад асуудлаар лавлагаа мэдээлэл авах хаяг:
Утас: +44 20 7338 7168; Цахим шуудан: projectenquiries@ebrd.com

Олон нийтийн мэдээллийн бодлого (ОНМБ)

Олон нийтийн мэдээллийн бодлого (ОНМБ) нь ЕСБХБ өөрийн стратеги, бодлого, үйл ажиллагааны талаархи олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх үүднээс мэдээллийг хэрхэн ил болгох, оролцогч талуудтай хэрхэн зөвлөлдөж ажиллах журмыг тодорхойлдог. Төрийн хэвшлийн захирлуудын зөвлөлийн тайлан илтгэл авах хүсэлтийг хэрхэн гаргах талаарх мэдээллийг доорх холбоосоор ОНМБ-ын вэб хуудсанд хандан авна уу.

Төслийн Гомдлын Газар (ТГГ)

Төслийн Гомдлын Газар (ТГГ) нь ЕСБХБ-ны эгэх хариуцлагын механизм, арга хэрэгсэл юм. Энэ нь ЕСБХБ-ны санхүүжилттэй төслүүд байгаль орчинд буюу нийгэмд хор хохирол учруулсан эсвэл учруулж болзошгүй гэж үзсэн хувь хүн болон байгууллагын зүгээс гаргасан гомдлыг хараат бусаар хянан үзэх боломж олгодог.

Гомдол хэрхэн гаргах талаар мэдээлэл авахыг хүсвэл [Project Complaint Mechanism](#) вэб хуудсанд хандана уу. ТГГ-ын ажилтан (pcm@ebrd.com) гомдол гаргах, гомдлын бүртгэл ба шаардлагын шалгуурт хэрхэн нийцүүлэх тухай асуудлаар таны аливаа асуултанд **ТГГ-ын Үйл ажиллагааны журам** -ын дагуу хариулахад бэлэн байна.